



**УЛААНБААТАР ХОТЫН
ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 4 дүгээр хэсгийн 4.9.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төвд шаардлагатай диспетчер инженерийн орон тоонд ажилтан сонгон шалгаруулж авах тухай зарыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэх ажлыг зохион байгуулахыг Хүний нөөц, дотоод асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн /Х.Эрдэнэбаяр/-д даалгасугай.

2. Зарыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэх ажилд шаардагдах 114.500 /нэг зуун арван дөрвөн мянга таван зуун/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /М.Ичинхорлоо/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Н.Батсүх/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.БАН-ОЧИР